

# Factsheet

SWISS AGENCY FOR DEVELOPMENT AND COOPERATION IN MONGOLIA

September 2015

Implemented by:



In cooperation with:



**IZB**  
Institute for International  
Cooperation in Education  
University of Teacher  
Education Zug

## FACTS

### Project name:

Education for Sustainable  
Development

### Duration:

2015-2017

### Budget:

SDC – CHF 8'460'000,  
Government  
of Mongolia - CHF 4'360'000

### Geographic coverage:

Mongolia (nationwide)

### Target group:

Students, teachers, parents, public,  
government, universities, civil society  
organisations, private sector

## EDUCATION FOR SUSTAINABLE DEVELOPMENT



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC

The Education for Sustainable Development (ESD) Project is supporting the ongoing integration of Education for Sustainable Development into the school system and in Mongolian society and the economy. Sustainable development means "development that meets the needs of the present generation without compromising the ability of future generations to meet their own needs". The Mongolian government has recognised the urgency of creating an environmentally, socially and economically sustainable future.

By engaging with key agents for change in this process, Mongolia will benefit from having an institutional and organisational framework that is conducive for sustainable development. A nationwide social movement is being fostered in the education system, including all 628 primary and secondary public schools. Educational institutions will in turn collaborate with communities and green businesses to mainstream sustainable development. Led by the country's own commitment and ownership, Mongolia's national reform of ESD is unique in the world.



Eco-schools promote green communities

## BACKGROUND

As a result of the mining boom, Mongolia is one of the fastest growing countries in the world. However, Mongolia's development also offers a lesson as economic growth alone doesn't lead to sustainable development. Minerals-dependent industrialisation brings with it threats to the ecological balance, including pollution, water shortages, land degradation, and exploitation of natural resources. With rapid urbanisation, Mongolian society is challenged by dynamic socio-

cultural changes, insecurities in everyday life and materialism. From these challenges, Mongolia learns the importance of shifting from a brown economy to green and equitable development. And in so doing, it recognises the importance of integrating sustainable development in its education system. The Government of Mongolia has initiated a comprehensive reform process to mainstream Education for Sustainable Development (ESD) and to create a green economy.

### SDC's Strategic Goal:

To contribute to equitable and sustainable social and economic development in Mongolia.

## ESD CONCEPT

Education plays an essential role in building the adaptation and mitigation capacities of communities and nations. Dealing with the wellbeing of all four dimensions of sustainability - environment, society, culture and economy - ESD promotes efforts to rethink educational programmes and systems (both methods and contents) that seek to build sustainable societies. Quality education designed with

the purpose of empowering young people to address ecological, social, economic and cultural issues is crucial in preparing communities for a sustainable future. While fostering sustainable development through the education system, the ESD simultaneously applies an equitable sustainability approach for the whole of society, including vulnerable groups, public institutions, the business community, civil society, institutional and legal frameworks, and public awareness-raising.

## PROJECT GOAL

ESD is integrated in the Mongolian school system, and a framework (institutional, legal and organisational) for sustainable development (SD) and green development (GD) is in place.

## PROJECT OUTCOMES

- **ESD is integrated and adjusted in the curriculum of all 628 schools (grades 1-12)**
- **Awareness among leaders and the public (adults, youth, parents, the community and organisations) on ESD/ SD/GD is increased, and selected companies and organisations are certified in accordance with ISO 14001 and key environmental standards.**

### Key results from SDC's previous intervention in ecological education

As one of the key actors promoting ESD in Mongolia's education system, SDC in Mongolia supported the establishment of Eco Schools within the Coping with Desertification Project from 2008. A nationwide movement among children to create a green environment in schools reached 177 schools in 11 aimags and in Ulaanbaatar, covering about 21 percent of public schools. Eco-schools have proven to be an effective tool for increasing environmental knowledge and the engagement of pupils, teachers and parents in local environmental issues, and associated behavioural change.



© ESD Project

Teachers are the key drivers of promoting ESD.  
Teachers' Training in Darkhan.

## RESULTS TO DATE AND EXPECTED

- 628 schools in Mongolia are having ESD integrated into the regular curricula, which are in a process of continued revision;
- 468,000 students and 25,000 teachers (of whom 81 percent are female) are directly involved;
- 2,680 teachers will be trained and empowered to promote ESD through the 117 already established Eco Schools;
- National public institutions such as the Mongolian State University for Education, the Education Research Institute, the Institute of Teachers' Professional Development and Life-Long Learning Centres are supported and strengthened to mainstream ESD throughout the country;
- ESD principles will be integrated in schools' management and evaluation systems;
- Selected public and private organisations and/or companies will be supported in developing green businesses in accordance with internationally recognised standards such as the ISO14001;
- A ministerial task force headed by the Ministry of Environment, Green Development and Tourism (MEGDT), reviewed the sustainable development indicators and fostered the implementation of the action plan for green economy.
- Mongolia is among the countries engaged in the Partnership for Action on Green Economy, an initiative led by different UN agencies such as UNEP, ILO, UNIDO, and UNITAR).

## Partners:

- Ministry of Education, Culture and Science
- Ministry of Environment, Green Development and Tourism

## Contacts:

### **Education for Sustainable Development Project office**

Midtown office, 4th floor  
Peace Avenue 15/2,  
Olympic Street, Sukhbaatar District,  
Ulaanbaatar, Mongolia

Tel: +976 75770989  
+976 99900765  
E-mail: [avid.enkhjargal@giz.de](mailto:avid.enkhjargal@giz.de)

### **Country Office of Deutsche Gesellschaft fuer Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH in Ulaanbaatar**

Naiman zovkhis building,  
Seoul Street 21  
P.O.Box 1264, Ulaanbaatar 14251  
Mongolia

Tel: +976 70115340  
Fax: +976 11 315342  
E-mail: [giz-mongolei@giz.de](mailto:giz-mongolei@giz.de)  
Web: [www.giz.de](http://www.giz.de)

### **Swiss Cooperation Office of The Embassy of Switzerland**

Sky Plaza Business Centre,  
Olympic street 12,  
Khoroo 1, Sukhbaatar district,  
Ulaanbaatar, Mongolia

P.O.Box 37, Ulaanbaatar 14210,  
Mongolia

Tel: +976 11 331 422  
Fax: +976 11 331 420  
E-mail: [ulaanbaatar@eda.admin.ch](mailto:ulaanbaatar@eda.admin.ch)  
Web: [www.swiss-cooperation.admin.ch/mongolia](http://www.swiss-cooperation.admin.ch/mongolia)

# ТӨСЛИЙН ТОВЧООН

## ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ

2015 оны 9-р сар

Хэрэгжүүлэгч:



Хамтран хэрэгжүүлэгч:



### БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Тогтвортой хөгжлийн боловсрол

Хэрэгжүүлэх хугацаа:

2015 – 2017 он

Төсөв:

ШХА - 8,460,000 шв.франк;  
Монгол Улсын Засгийн  
газар - 4,360,000 шв.франк

Газар зүйн хамрах хүрээ:

Монгол Улсын хэмжээгээр

Зорилтот бүлгүүд:

Сурагчид, багш нар, эцэг эхчүүд,  
олон нийт, их дээд сургуулиуд,  
иргэний нийгмийн байгууллагууд,  
хувийн хэвшлийн байгууллагууд

### ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн  
засгийн эрх тэгш, тогтвортой  
хөгжилд хувь нэмэр оруулахыг  
зорино.



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ ТӨСӨЛ

Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) төсөл тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг боловсролын системд нэвтрүүлж Монголын нийгэм, эдийн засагт төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. “Тогтвортой хөгжил” гэдэг нь ирээдүй хойч үеийн хэрэгцээгээ хангах чадварыг алдагдуулахгүйгээр одоо үеийн эрэлт хэрэгцээг хангах хөгжлийг хэлнэ. Энэ үүднээс байгаль орчинд элтэй, нийгэм, эдийн засгийн хувьд тогтвортой ирээдүйг цогцлоох нэн шаардлагатай байгааг төр засаг хүлээн зөвшөөрөөд байна.

Монгол улс энэхүү өөрчлөлтийн үйл явцын гол оролцогч болсноор тогтвортой хөгжилд чиглэсэн институцийн болон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж түүнийхээ үр шимиийг хүртэх ач холбогдолтой. Боловсролын тогтолцоонд, түүний дотор улсын 628 бага, дунд сургуульд энэхүү улсын хэмжээний нийгмийн хөдөлгөөнийг дэмжин хөгжүүлж байна. Боловсролын байгууллагууд эргээд олон нийт, ногоон бизнес эрхлэгчидтэй хамтран тогтвортой хөгжлийн үзэл санааг төлөвшүүлэх юм. ТХБ-ын үндэсний шинэтгэлийг Монгол улс өөрийн онцлогт нийцүүлэн удирдан чиглүүлж байгаагаараа онцлогтой.



Эко сургуулиуд ногоон хөгжилд хувь нэмэрээ оруулж байна

© Д.Давааням

### ҮНДЭСЛЭЛ

Уул уурхайн салбарын эрчимтэй хөгжлийн үр дүнд Монгол улс дэлхийн хамгийн хурдацтай хөгжих буй орнуудын нэг болоод байна. Гэвч эдийн засгийн өсөлт дангаараа тогтвортой хөгжлийг бий болгодоггүй гэдгийг Монгол улсын хөгжлийн сургамж харуулж байна. Эрдэс баялагаас хамааралтай аж үйлдвэржилт нь экологийн тэнцвэртэй байдлыг алдагдуулах, байгаль орчны бохирдол, усны хомсдол, газрын доройтол, байгалийн нөөц шавхагдах аюулд хүргэж байна. Монголын нийгэмд хотжилт эрчимтэй явагдснаар нийгэм,

соёлын эрс өөрчлөлтүүд гарч, өдөр тутмын амьдралын баталгаа алдагдах, эд шүтэх үзэл хөгжих асуудал тулгарч байна. Эдгээр тулгамдсан асуудлаас үүдэн Монгол улс хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг, эрх тэгш хөгжилд шилжихийн ач холбогдлыг ойлгож эхлээд байна. Үүний тулд нийгэмд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх нь чухал. Монгол Улсын Засгийн газраас тогтвортой хөгжлийн боловсролыг (ТХБ) төлөвшүүлэх, ногоон эдийн засаг бий болгох өргөн хүрээтэй шинэтгэлийн үйл явцыг эхлүүлээд байна.

## ТХБ-ЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Аливаа нийгэм, улс үндэстний дасан зохицох, даван туулах чадавхийг бэхжүүлэхэд боловсрол чухал үүрэг гүйцэтгэдэг. ТХБ нь тогтвортой байдлыг байгаль орчин, нийгэм, эдийн засаг, соёлын бүх дөрвөн хэмжээсээр авч үзсэнээр боловсролын хөтөлбөр, тогтолцоог (арга зүй, агуулгын хувьд) шинэчлэн тогтвортой нийгэм байгуулах хүчин чармайлтыг хөхиүүлэн дэмждэг. Залууст нийгэм, эдийн засаг, экологи, соёлын асуудлуудаа

шийдвэрлэх чадвартай болгоход чиглэсэн чанартай боловсрол олгох нь иргэд, олон нийтийг тогтвортой ирээдүйд бэлтгэхэд чухал ач холбогдолтой. ТХБ нь боловсролын тогтолцоогоор дамжуулан тогтвортой хөгжлийг дэмжихийн зэрэгцээ нийгэм бүхэлдээ, түүний дотор эмзэг булэг, төрийн болон бизнесийн байгууллагууд, иргэний нийгэм, институцийн болон эрх зүйн хүрээнд эрх тэгш, тогтвортой байдлаар хөгжих, энэ талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх боломж олгодог.

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

ТХБ-ын үзэл санаа, ойлголтыг Монгол улсын боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхийн зэрэгцээ тогтвортой хөгжил (TX), ногоон хөгжлийн (HX) (институцийн, эрх зүйн, зохион байгуулалтын) орчинг бүрдүүлэхэд оршино.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН

- ТХБ-ын үзэл санааг нийт 628 сургуулийн (1-12 дугаар анги) сургалтын хөтөлбөрт суулгасан байна.
- Шийдвэр гаргагчид, олон нийтийн (насанд хүрэгсэд, залуучууд, эцэг эхчүүд, иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллагууд) ТХБ, TX, HX-ийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад байгаль орчны удирдлагын тотолцоог нэвтрүүлж, ISO 14001 баталгаажуулалт хийлгэсэн байна.

## ШХА-аас хэрэгжүүлсэн Эко сургууль төслийн гол үр дүнгүүдээс

Монголын боловсролын тогтолцоонд ТХБ-ыг оруулахыг хөхиүүлэн дэмжигч гол оролцогч нарын нэг Монгол дахь ШХА 2008 оноос эхлэн Цөлжилтийг саруулах төслийнхөө хүрээнд Эко сургуулиуд байгуулахад дэмжлэг үзүүлж ирсэн. Улмаар хүүхдүүд сургуулийнхаа эргэн тойронд ногоон орчин байгуулах хөдөлгөөн улсын хэмжээнд өрнөж Улаанбаатар хот, 11 аймгийн 177 сургуулийг хамрах болсон нь нийт улсын сургуулидын 21 хувийг эзлэж байлаа. Эдгээр эко сургууль нь сурагчдын байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, сурагчид, багш нар, эцэх эхчүүдийн орон

нүтгийн байгаль орчны асуудалд оролцох оролцоог дээшлүүлэх, холбогдох зан үйлийн өөрчлөлт гаргах үр дүнтэй хэрэгсэл болох нь нотлогдоод байна.

## ХҮРСЭН БОЛОН ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Монгол улсын нийт 628 сургуулийн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санааг нэвтрүүлж, сайжруулах ажил хийгдэж байна;
- Хөтөлбөрт нийт 468,000 сургач, 25,000 багш (үүнээс 81 хувь нь эмэгтэй) шууд хамрагдаад байна;
- Байгуулагдаад байгаа 117 эко сургуулиудаар дамжуулан 2,680 багшийг ТХБ-ыг дэмжин хөгжүүлэх чиглэлээр сургана;
- ТХБ-ын үзэл санааг орон даяар дэлгэрүүлэн хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Боловсролын их сургууль, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Насан туршийн боловсролын төв зэрэг байгууллагуудад дэмжлэг үзүүлэн чадавхийг нь бэхжүүлнэ;
- ТХБ-ын зарчмуудыг сургуулиудын удирдлага, үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлнэ;
- Сонгогдсон төрийн ба хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ISO14001 зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу ногоон бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан яамны ажлын хэсэг тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг хянан үзэж, ногоон хөгжлийн бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэд дэмжлэг үзүүлнэ.;
- НҮББОХ, ОУХБ, НҮБАҮХБ, НҮБССХ зэрэг НҮБ-ын байгууллагуудын санаачилсан Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлд Монгол улс нэгдсэн.



© ТХБ төслийн

ТХБ-ыг нэвтрүүлэхэд багш нарын үүрэг оролцоо чухал. Дархан-Уул аймагт болсон багш нарыг бэлтгэх сургалт

## Хамтран хэрэгжүүлэх түншүүд:

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам

## Холбоо барих:

### Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл

Мидтаун оффис, 4-р давхар Энх тайвны өргөн чөлөө 15/2, Олимпийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976 75770989  
+976 99900765;  
И-мэйл: avid.enkhjargal@giz.de

### Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Улаанбаатар дахь оффис

Найман зовхис төв, Сөүлийн гудамж 21  
Шуудангийн хайрцаг 1264,  
Улаанбаатар 14251  
Монгол улс

Утас: +976 70115340  
Утас: +976 11 315342  
И-мэйл: giz-mongolei@giz.de  
Вэб хуудас: www.giz.de

### Монгол дахь Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай плаза бизнес төв,  
Олимпийн гудамж 12,  
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 14210,  
Монгол улс

Утас: +976 11 331 422  
Факс: +976 11 331 420  
И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch  
Вэб хуудас: www.swiss-cooperation.admin.ch/mongolia